



**“БОЛОВСРОЛЫГ БҮХ НИЙТЭД!  
БҮХ НИЙТ БОЛОВСРОЛЫН ТӨЛӨӨ!”**

# **БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙР СУУРЬ**

**БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ**

Улаанбаатар хот 2023 он

## “БОЛОВСРОЛЫГ БҮХ НИЙТЭД! БҮХ НИЙТ БОЛОВСРОЛЫН ТӨЛӨӨ!”

### БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙР СУУРЬ

*“Бидний хүсэл, хүн бүрд хүртээмжтэй; хүний эрх, жендерийн тэгш эрхэд суурилсан; цогц чадамжийг өөртөө тохиромжтойгоор, ялгаварлан гадуурхалтгүйгээр, насан туршдаа эзэмших боломжтой; эрүүл, аюулгүй орчин бүрдсэн; ялгаатай хэрэгцээг хангасан; хүмүүнлэг, ардчилсан; бүх нийтийн; хангалттай санхүүжилттэй; сайн засаглал бүхий чанартай, хувиран өөрчлөгдөх боловсролын тогтолцоотой болох”*

**“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл**

### НЭГ. Боловсролын өнөөгийн дүр зураг, тулгамдаж буй асуудал

1. Улсын хэмжээнд 2021-2022 оны хичээлийн жилд 1,453 цэцэрлэгт 190.9 мянган хүүхэд, 848 ерөнхий боловсролын сургуульд 717.4 мянган сурагч, 75 техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад 45.3 мянган залуус, 88 дээд боловсролын сургалтын байгууллагад 148.9 мянган оюутан сурч байна.<sup>1</sup>
2. Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор 10, түүнээс дээш насны нийт хүн амын 4.9 хувь буюу 159,726 нь боловсролгүй гэсэн дүн гарчээ. Монгол Улсын нийт хүн амын 1.3 хувь буюу 36,519 нь бичиг үсэгт тайлагдаагүй.<sup>2</sup> 2010 онтой харьцуулахад хүн амын бичиг үсэг тайлагдалт, боловсролын түвшинд эерэг өөрчлөлт гарсан. Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын бараг тал хувь нь бичиг үсэг тайлагдаагүй эсвэл боловсролгүй.<sup>3</sup>
3. Арав, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшинг хүйсээр ангилж үзэхэд бүрэн дундаас доош боловсролтой эрэгтэйчүүдийн хувийн жин эмэгтэйгээс илүү, харин тусгай мэргэжлийн дунд болон дээд боловсролтой эмэгтэйчүүдийн хувийн жин эрэгтэйгээс илүү байна. 2020 оны тооллогын дүнгээс харахад дээд боловсролтой 5 хүн тутмын 3 (дипломын 60.6 хувь, бакалаврын 59.7 хувь) нь, магистрын дипломтой 3 хүн тутмын 2 (65.8 хувь) нь эмэгтэйчүүд байгаа нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү өндөр түвшний боловсрол эзэмшиж байгааг харуулж байна<sup>4</sup>.
4. 6-15 насны хүн амын 11.4 мянга (1.9 хувь) нь сургуульд суралцахгүй байгаа бөгөөд өмнөх тооллогоос 5.2 мянгаар (1.7 пунктээр) буурсан байна. 6-15 насны сургуульд сурдаггүй хүүхдийн 8.0 мянга (70.2 хувь) нь хот, 3.4 мянга (29.8 хувь) нь хөдөө орон нутгийн хүүхэд байна. Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын дүнгээр 2-5 насны нийт 312.2 мянган хүүхдийн 49.6 мянга (15.9 хувь) нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдаагүй.<sup>5</sup>

<sup>1</sup> Боловсролын салбарын статистикийн мэдээлэл, БШУЯ, ҮСХ, 2022 он.

<sup>2</sup> ХАОСТ: Боловсрол, бичиг үсгийн мэдлэг, Сэдэвчилсэн судалгаа, ҮСХ, 2020 он.

<sup>3</sup> Монгол Улсын хүний хөгжлийн илтгэл, Монгол Улсын Засгийн газар, НҮБХХ, 2016 он

<sup>4</sup> ХАОСТ: Боловсрол, бичиг үсгийн мэдлэг, Сэдэвчилсэн судалгаа, ҮСХ, 2020 он.

<sup>5</sup> Мөн тэнд

5. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт харьцангуй нэмэгдэж байсан авч Ковид-19 цар тахлын шалтгаант хичээл сургалтын үйл ажиллагаа тасалдсантай холбоотойгоор, мөн СӨБ-д хамрагдах насанд хийсэн зохицуулалттай холбоотойгоор 2021-2022 оны хичээлийн жилийн эхэнд өмнөх жилээс (247.0 мян.) 56.0 мянгаар буурсан (190.9 мян.) бөгөөд нэмэлт элсэлт авснаар цэцэрлэгт хамрагдалт 10.0 мянган хүүхдээр буурсан мэдээтэй байна<sup>6</sup>. Малчдын хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй, амьжиргааны түвшин доогуур өрхийн хүүхдүүд, казак өрхийн хүүхдүүд зэрэг бага насны хүүхдийн халамж ба боловсролд хамрагдах нэн хэрэгцээтэй байгаа хүүхдүүд үйлчилгээний гадна байсан хэвээр.
6. 2021-2022 оны хичээлийн жилд бага боловсролд хамрагдвал зохих 6-10 настай нийт хүүхдийн 3.0 хувь буюу 11.4 мянган хүүхэд, дунд ангид хамрагдвал зохих 11-14 насны нийт хүүхдийн 3.7 хувь буюу 9.2 мянган хүүхэд сургуульд хамрагдаагүй байна. Харин дунд ангид хамрагдаагүй нийт хүүхдийг хүйсээр авч үзвэл 59.4 хувь нь эрэгтэй хүүхэд байна<sup>7</sup>. Мөн СӨБ-ын хуулиар заавал хамрагдах ёстой 5 настай хүүхдийн хамран сургалт 91.3 хувьтай байгаа аж.
7. Өнөөдрийг хүртэл нүүдлийн соёл иргэншлээ хадгалан үлдсэн улсын хувьд энэ онцлогтоо тохирсон боловсролын тогтолцоог бүрдүүлэх шаардлагын дагуу 2021-2022 оны хичээлийн жилийн байдлаар 47,030 орны хүчин чадалтай 548 дотуур байр ажиллаж, дотуур байранд 34,546 хүүхэд амьдрах хүсэлт гаргаснаас 32,576 хүүхэд амьдарч байна. Хүсэлт гаргасан нийт хүүхдийн 26,458 нь малчин өрхийн хүүхэд ажээ. Үүнээс 25,169 нь дотуур байранд амьдардаг. Ихэнх дотуур байрны материаллаг болон сэтгэл зүйн орчин нөхцөл туйлын хангалтгүй, барилгын халаалт дулаан, цэвэр ус, ариун цэврийн байгууламж гэх мэт дэд бүтэц доголдолтой.
8. Улаанбаатар хотод үүссэн хүн амын төвлөрөл ихэнх сургууль, цэцэрлэгийн ачааллыг эрс нэмэгдүүлж, анги дүүргэлтийг норм хэмжээнээс хэд дахин хэтрүүлж, хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжил, сургалтын чанарт эрсдэл учруулах хэмжээнд хүрсэн. ЕБС-ийн нэг бүлэгт ногдох хүүхдийн тоо сүүлийн 8 жилийн хугацаанд аажмаар өсч байгаа.
9. Хүүхдийг бие хүн болгон төлөвшүүлэх, нийгэмшүүлэхэд зайлшгүй шаардлагатай иргэний боловсрол, эрүүл мэнд, бэлгийн боловсрол, амьдрах ухааны гэх мэт хичээлүүдийн хөтөлбөр хангалттай сайн боловсруулагдаагүй, багш нарт энэ чиглэлээр зайлшгүй байвал зохих ур чадвар суралцаагүй байна. Иргэний ёс зүйн боловсролыг бүхэлд нь монгол өв соёл, уламжлал, заншил, буддын мэдлэг ухаанаар тодорхойлон гаргасан нь агуулга болон арга зүйн хувьд алдаатай болжээ<sup>8</sup>. Одоо мөрдөгдөж байгаа сургалтын цөм хөтөлбөрт нөхөн үржихүйн эрүүл мэнд, бэлгийн цогц боловсролын агуулга хангалтгүй тусч, товч мэдлэг олгохоор хязгаарлагдсан бөгөөд хувь хүнд хэрэгтэй ур чадвар, зан үйл, нийгэм соёлын харилцааны асуудлууд<sup>9</sup> орхигдсон.

<sup>6</sup> СӨБ-ын 2021-2022 оны нэмэлт элсэлтийн 4-р сарын тайлан, БШУЯ-ны статистик

<sup>7</sup> Боловсрол, шинжлэх ухаан, оюуны өмч. Салбарын танилцуулга, ҮСХ, 2021 он

<sup>8</sup> “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөр, агуулгад хийсэн шүүмжлэлт зарим эргэцүүлэл”, М.Отгонбаяр, Б.Дагзмаа, МУИС, 2022 он

<sup>9</sup> Бэлгийн цогц боловсрол: Нотолгоонд суурилсан нөлөөллийн баримт бичиг, МОНФЕМНЕТ үндэсний сүлжээ, 2016 он

10. Монгол Улсын тухайд бүх нийтийн ерөнхий боловсрол үнэ төлбөргүй бөгөөд суурь боловсролыг заавал эзэмшихээр хуульчилсан. Гэсэн хэдий ч боловсролын шууд бус зардлууд болох хичээлийн хэрэглэл, дүрэмт хувцас, унаа, хоолны зардал нь нийгэм эдийн засгийн хувьд статус доогуур гэр бүлийн хувьд хүүхдийнхээ боловсролын зардлыг хүчрэх аргагүй болгодог. Сургуульд байгаа хүүхдийнхээ шууд бус зардлыг төлж чадахгүй тохиолдолд хүүхэд үе тэнгийнхнээсээ ичих, багш нар “хичээлийн бэлтгэлгүй ирлээ” хэмээн буруутгах, шийтгэх нь нэмэгдвэл нийгэм-соёлын саад нэмэгдэж сургуулиас гарахад хүргэдэг<sup>10</sup> явдал нийтлэг байна.
11. 2021-2022 оны хичээлийн жилд үйл ажиллагаа явуулж буй нийт 1453 цэцэрлэгийн 481 (33.1%) нь хувийн өмчийн цэцэрлэг байна. Нийт хамрагдсан хүүхдийн (191.0 мян) хүүхдийн 31.2 мянга (16.3%) нь хувийн өмчийн цэцэрлэгт хамрагдаж байна. ЕБ-ын 848 сургуулийн 166 (19,6%) хувийн өмчийн сургууль байгаа бөгөөд суралцагчдын 53,719 нь хувийн өмчийн сургуульд суралцаж байна. Хувийн цэцэрлэг, сургуулийн тоо 2013 оноос хойш тасралтгүй нэмэгдэх хандлагатай болсон. Ашгийн төлөөх сургуулиудын сүлжээ нь сурч боловсрох эрхийг хэрэгжүүлэх байдлыг гажуудуулах төдийгүй ардчилал, нийгмийн эв эе, хөгжиж буй орнуудын тогтвортой байдал зэрэгт хор хохирол учруулж байгаа<sup>11</sup>.
12. Хөгжлийн бэрхшээлтэй нийт хүүхдийн 36.6 хувь нь сургуулийн гадна эсвэл сургууль завсардсан<sup>12</sup> байгаа нь ердийн сургуульд тэгш хамран сургах соёл, бодлого, үйл ажиллагаа хэвшээгүйтэй холбоотой байна. Тэдний боловсролд хамрагдалт, сургалтын чанар, үр дүнгийн талаар найдвартай тоо, мэдээлэл өнөөг хүртэл гарахгүй хэвээр.
13. Баян-Өлгий аймгийн хүн амын дийлэнх нь казах үндэстнүүд. Үндэстний цөөнхийн хүүхдүүд хүнс тэжээл, сургуулийн өмнөх насны боловсрол, суурь боловсрол эзэмшиж буй байдал зэргээрээ бусад бүс нутгийн хүүхдүүдтэй харьцуулахад ихээхэн сул байна.<sup>13</sup> Ялангуяа, казах, тува зэрэг үндэстний цөөнхийн хувьд эх хэлээрээ боловсрол эзэмшихэд нь саад бэрхшээл тулгарч байгаа нь бодлого боловсруулагчид тэгш байдлыг зөвхөн үл ялгаварлах, гадуурхах, тодорхой бүлгийг хориглохгүй байх зэргээр харж, харин сурах тэгш боломжоор хангах, сургалтын тэгш үр дүнд хүрэх онцгой хэрэгцээ гэж төдийлөн анхаарахгүй байгаатай холбоотой.
14. Сургууль, боловсролын орчин дахь багш нарын жендэрийн мэдрэмжгүй байдал, сурах бичгийн зураг, дүрслэл, эхэд эрэгтэйчүүдийн дүр хэт давамгайлж байгаа ба эрэгтэй, эмэгтэйчүүдийн дүр үүрэг, сэтгэл зүйн шинжүүдийг жендэрийн хэвшмэл ойлголт, өрөөсгөл хандлагаар дүрсэлсэн нь нэлээд хувийг эзэлж байгаа нь сурагчдад жендэрийн эерэг соёл төлөвшин хөгжихөд хүндрэл учруулж болзошгүй байна. Жендэрийн эрх тэгш байдлын боловсролд сөрөг нөлөө үзүүлэхүйц сургалтын хэрэглэгдэхүүнийг ашиглахаас урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдээгүй байна<sup>14</sup>.

<sup>10</sup> “Тодорхой бүлгийн хүүхдүүдэд боловсрол эзэмшихэд нь тулгардаг саад тотгорууд” Чанарын судалгааны тайлан, доктор М.Батбаатар, МУИС, “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэстний эвсэл, 2020 он

<sup>11</sup> A/HRC/29/30, para. 39

<sup>12</sup> ХБХХЕГ, ҮСХ, 2022 он

<sup>13</sup> Монгол улсын хөгжлийн төлөв байдлын шинжилгээ, Монгол дахь Нэгдсэн Үндэстний Байгууллага, 2021 он

<sup>14</sup> Жендэрийн Үндэстний хороо, “Монгол Улсын жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ”, 2021 он.

15. Боловсролын тогтолцоо нь ялгаварлан гадуурхалтыг арилгахад хангалттай хариу үйлдэл үзүүлж чадахгүй байгаагаар зогсохгүй, гарсан тохиолдолд үр дүнтэй хариу үйлдэл үзүүлж, хариуцлага тооцож чадахгүй байна. Орлого багатай өрхийн хүүхдүүд, шилжин суурьшсан болон бүртгэлгүй хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, үндэстний цөөнх хүүхдүүд, бэлгийн цөөнх хүүхдүүд, жирэмсэн охид болон өсвөр насны эхчүүд, унаач хүүхэд<sup>15</sup> гэх мэт эмзэг, хүнд нөхцөлд байгаа хүүхдүүд боловсролын орчинд ялгаварлан гадуурхалтанд өртдөг.
16. Монголчуудын дөрөвний нэгээс илүү хувь нь орлогын ядууралд өртсөн бөгөөд ядуурал, эмзэг байдал үе дамжин үргэлжлэх хандлагатай болж, нийгэмд тэгш бус байдал гүнзгийрч байгаа нь сэтгэл зовоосон асуудал мөн. Ковид-19 цар тахлын уршгаар орлогын болоод эд хөрөнгө, боловсролын үйлчилгээний тэгш бус байдал улам бүр нэмэгдэж, хямралын сөрөг үр дагавар ч цааш удаан үргэлжлэх төлөвтэй байна<sup>16</sup>.
17. Сургуулийн багш, ажилтнуудтай хийсэн ярилцлагаар сургуулийн орчин дахь үе тэнгийн дээрэлхэлт эрс нэмэгдэж цахим орчин руу илүү шилжсэн, үүнтэй холбоотойгоор 6-9 ангийн сурагчдын дунд хамгийн түгээмэл байдаг байна. Хүүхдүүд нийгмийн сүлжээгээр бие биеэ гутаан доромжлох, худал мэдээлэл тараах, өмссөн хувцас, ар гэрийн байдлаар нь ялгаварлан, гадуурхах явдал түгээмэл байна. Харилцаа холбооны зохицуулах хорооны дээрх судалгаанд оролцсон хүүхдийн 50% нь цахим дарамтад өртөж байсан тэдний ердөө 15% нь энэ талаар эцэг эхдээ хэлсэн байна.<sup>17</sup>
18. Сургуулийн дотуур байрны хүүхэд нь хүүхдийн эсрэг дарамт, үл хайхрах явдалд голлон өртөх эрсдэлтэй. Түүнээс гадна хүүхдийг асаргаа халамж үзүүлэх, харж, хянах явдал ялангуяа шөнийн цагаар их сул. Үр дагавар нь орлого багатай айлын хүүхдүүд эмзэг байдалдаа үлдэж дотуур байрандаа үе тэнгийнхний, харин дотуур байрнаас гадна амьдардаг хүүхэд орон нутгийн зарим хүний зүгээс дээрэлхэлт, мөлжлөгт өртдөг. Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд дотуур байрны хүүхдийн өвөрмөц хэрэгцээтэй эмзэг бүлгийн хүүхдэд чиглэж маш бага зүйлийг хийжээ.<sup>18</sup>
19. “Багш, сургуулийн өмнөх боловсрол”, “Багш, бага боловсрол” хөтөлбөрөөр мэргэжилтэн бэлтгэж буй хот, хөдөөгийн 28 их, дээд сургууль, коллежийн сургалт, хөтөлбөрийн чанарыг үнэлэх зорилгоор 2 болон 3 дугаар курсэд суралцаж буй 9,583 суралцагчдын дунд шалгалт, судалгаа хийж үзэхэд дунджаар 39.5-55.6%-ийн гүйцэтгэлтэй гарсан байна.<sup>19</sup> Мөн багш бэлтгэх тогтолцооны хоцрогдсон байдал сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын чанарт сөргөөр нөлөөлсөөр байна.

<sup>15</sup> “Монгол улс дахь хүний эрхийн төлөв байдал: тулгамдсан асуудал, шийдэл” Тойм судалгаа, О.Мөнхсайхан, Р.Очирбал, 2021 он

<sup>16</sup> Монгол улсын хөгжлийн төлөв байдлын шинжилгээ, Монгол дахь Нэгдсэн Үндэстний Байгууллага, 2022 он

<sup>17</sup> Хүүхэд хамгааллын тогтолцооны зураглал судалгааны тайлан, “Дэлхийн Зөн Монгол” олон улсын байгууллага, “Тогтвортой хөгжлийн санаачилга” ТББ, 2021 он

<sup>18</sup> Хүүхэд хамгааллын тухай Монгол Улсын хуулийн хэрэгжилтийн үнэлгээний тайлан Корам Интернейшнл байгууллага, НҮБХС, 2021 он

<sup>19</sup> Дээд боловсролын сургалтын байгууллагын сургалт, хөтөлбөрийн чанарыг үнэлэх шалгалт, судалгааны ерөнхий дүн мэдээ, БҮТ, Дээд боловсролын шинэчлэлийн төсөл, 2019

20. Багшийн “далд хомсдол” үүссэн байсныг судалгаанууд нотолсоор<sup>20</sup> байсан ч бодлогын дорвитой хариу үйлдэл үзүүлээгүйгээс багш дутагдах үзэгдэл хот, орон нутгийн сургууль, цэцэрлэгүүдэд бодит байдал боллоо. Багшийн ажлын нөхцөлтэй харьцуулахад, цалин хөлсний хэмжээ, нийгмийн баталгааны байдал тэднээс шаардаж байгаа хариуцлага нь хэт тэнцвэргүй байгаагаас үүдэлтэй багш дутагдаж байх магадлалтай. Багшид шаардлагатай байгаа бүх талын дэмжлэг үзүүлэхгүйгээр хатуу чанд датад суурилсан хариуцлага тооцох тогтолцоог ажиллуулж эхлэх нь эрсдэлтэй гэдгийг судлаачид анхааруулдаг.
21. Боловсролын чанар, суралцагчдын сурлагын амжилтыг үнэлэх судалгаа нь бага, суурь, бүрэн дунд боловсролын V, IX, XII ангийн суралцагчдаас түүврийн аргаар нийт суралцагчдын 10 хувийг хамруулан 2014 оноос эхлэн жил бүр зохион байгуулсан. Боловсролын чанар, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, суралцагчдын мэдлэг, чадварын түвшинг улсын хэмжээнд 6 жилийн дунджаар авч үзэхэд бага боловсролын түвшинд 47.0 хувь, суурь боловсролын түвшинд 38.6 хувь, бүрэн дунд боловсролын түвшинд 34.9 байна. Боловсролын чанарын үнэлгээний ерөнхий үр дүнгээс харахад сургалтын чанар, суралцагчдын сурлагын амжилт бага боловсролоос дээшлэх тусам өөрөөр хэлбэл суурь, бүрэн дунд боловсролын түвшинд харьцангуй буурч байгаа хандлага харагдаж байна<sup>21</sup>.
22. Сургалтын чанар хангалтгүй, төгсгөж буй мэргэжил нь зах зээлийн эрэлт, шаардлагад нийцэхгүй байгаагаас мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, их дээд сургууль төгссөн олон залуучууд ажлын байргүй<sup>22</sup> байсаар байна. Олон тооны, чанаргүй их, дээд сургуульд хүүхдээ сургах нэрийдлээр эцэг эх нь ядууралд нэрвэгдэх явдал түгээмэл гарч байгааг анхаарууштай.
23. Сургууль дээр мэргэжлийн чиг баримжаа олгох, сурлагын хоцрогдлыг арилгах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, биеэ авч явах байдал, зан үйлийн доголдол, сурах бэрхшээлтэй хүүхдүүдтэй тусгайлан ажиллах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тулгарч байгаа саад тотгоруудыг болон боловсролын эрэлт хэрэгцээг тодорхойлох зэрэг боловсролын бусад үйлчилгээг<sup>23</sup> огт үзүүлэхгүй байна.
24. Багш, хүүхэдтэй ажилладаг бусад мэргэжилтний хүүхдэд хандах хандлагыг өөрчлөх, эцэг эх, хүүхэд, нийт хүн амын дунд хүүхдийн эрхийн ойлголтыг сайжруулах, хүчирхийллийн бус, эерэг хүмүүжлийн арга барилыг сурталчлах, сэтгэл санааны хүчирхийллийн талаар ойлголтыг дээшлүүлэх зөвлөмжийг НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хороо өгсөн ч хангалттай биелээгүй. Сургууль дээрх нийгмийн ажлын



<sup>20</sup> Боловсролын чанар, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийн бодлогын судалгаа, Боловсролын хүрээлэн, 2020 он

<sup>21</sup> Боловсролын чанарын үнэлгээний үр дүн, түүнд нөлөөлж буй хүчин зүйл, сайжруулах санал, дүгнэлт, БҮТ, 2020 он

<sup>22</sup> Монгол улсын боловсролын бодлогын тойм шинжилгээ: Насан туршийн суралцахуйн тогтолцоог бүрдүүлэх нь, ЮНЕСКО, 2019 он

<sup>23</sup> “Боловсролын хуулийн шинэчлэл: Иргэний нийгмийн санал” Нөлөөллийн баримт бичиг, “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл, 2021 он

үйлчилгээг чанаржуулахын тулд нийгмийн ажлын үйлчилгээний стандартыг хэрэгжүүлэхэд ач холбогдол өгч, нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхэд кейстэй ажиллах арга зүй, мэргэжлийн удирдлагаар хангах чиглэлд илүү анхаарал хандуулах хэрэгтэй.<sup>24</sup>

25. Хүүхдийн боловсрол, хөгжил, төлөвшлийн асуудалд цогцоор хандах шаардлагатай байна. Эрүүл мэнд, хүүхэд хамгаалал, нийгмийн халамж, хот төлөвлөлт зэрэг салбаруудтай хамтран ажиллах шаардлага боловсролын салбарт тулгарч байна. Нэг ч цэцэрлэг, сургууль, хүүхдийн тоглоомын талбайгүй хороо Улаанбаатар хотод байсаар байна<sup>25</sup>. Хүүхдэд зориулсан нэвтрүүлэг, ном зохиол, хүүхэд залуусын чөлөөт цагаа өнгөрөөх, хөгжүүлэх газар, хүүхэд хөгжүүлэх төв, өдөр өнжүүлэх бүлэг зэрэгт хангалттай анхаарч, хөрөнгө оруулах явдал дутмаг байна<sup>26</sup>.

26. Боловсролын салбарт нэн шаардлагатай байгаа боловсролын эдийн засагч, сэтгэл зүйч, боловсролын үнэлгээний мэргэжилтнүүд, мэргэшсэн судлаач нарыг бэлтгээгүй, ялангуяа сургууль цэцэрлэгийн удирдах ажилтнуудыг тусгайлсан хөтөлбөрөөр бэлтгэдэггүй, хүний нөөц, төсөв, санхүүгийн удирдлага, манлайлал, байгууллагын хөгжлийн асуудлаар мэргэшүүлдэггүй<sup>27</sup> нь боловсролын үйлчилгээний чанарт ихээхэн нөлөөлж байна.

27. Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын асуудал шийдлээ хүлээсэн хэвээр. Хүчирхийлэл, үл хайхрах байдалд өртөх өндөр эрсдэлтэйгээс гадна боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ авах эрх нь зөрчигдөж буй сүм хийдэд шавилан сууж буй хүүхэд, эцэг эх нь гадаад болон дотоодод шилжин суурьшсны улмаас бусдын асрамжинд амьдардаг хүүхдүүд, дотуур байранд амьдардаг малчдын хүүхэд, өрх толгойлон амьдардаг хүүхэд<sup>28</sup> зэрэг эцэг эхийн хараа хяналтаас гадуур амьдарч буй хүүхдүүдийн талаар тусгайлсан арга хэмжээ авахгүй байна.

28. Насанд хүрэгчдийн, ялангуяа орлого багатай иргэд, алслагдмал нутагт оршин суугчид, ахимаг насны, хөгжлийн бэрхшээлтэй зэрэг хүмүүсийн тасралтгүй суралцах боломж нэн хязгаарлагдмал байсаар.

29. Судалгааны хүрээнд (1) ахмад настай иргэд, (2) хөгжлийн бэрхшээлтэй иргэд (3) амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэд, (4) шилжин суурьшсан өрх, (5) алслагдмал бүсэд амьдардаг өрх гэсэн 5 зорилтот бүлгийн төлөөллийн



<sup>24</sup> Мэдээлэл, Сургуулийн нийгмийн ажилтны нийгэмлэг, 2023 он

<sup>25</sup> Нийслэлийн засаг даргын мэдээлэл, 2022 лн

<sup>26</sup> "ЕБС-ийн дунд ангийн хичээлээс гадуурх үйл ажиллагаанд хийсэн хөндлөнгийн үнэлгээ", Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг, 2018 он

<sup>27</sup> 2020 оны парламентын сонгуульд оролцох намуудын мөрийн хөтөлбөрт тусгах санал, "Бүх нийт боловсролын төлөө!" Иргэний нийгмийн үндэсний эвсэл, 2020 он

<sup>28</sup> НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос Монгол Улсын Засгийн газарт өгсөн зөвлөмж, 2017 он

цахим ур чадварыг үнэлэхэд эдгээр бүлэгт гар утас, компьютерийн хүртээмж цахим бүтээгдэхүүн, үйлчилгээ авах зэрэг өөрсдийн хэрэгцээг хангахад хангалтгүй, цахим ур чадварын хувьд ахмад настай иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цахим ур чадвар бусад бүлгийн иргэдтэй харьцуулахад хамгийн бага байна.<sup>29</sup>

30. Албан бус боловсролын төвүүд насан туршийн боловсролын төв болж нэрээ өөрчилсөн ч нийт хүн амд, ялангуяа 15 ба түүнээс дээш насны иргэдэд зориулсан бичиг үсгийн боловсрол, амьдралд хэрэгтэй ур чадвар, сонгогчдын боловсрол олгох зэрэг олон төрлийн хөтөлбөр үгүйлэгдсэн.
31. Боловсролын аль ч шатанд ёс зүй, авилгын шинжтэй асуудлууд их байна. Тухайлбал, төгсөлтийн гэрчилгээг хуурамчаар олгох, шийдвэр гаргах эрх бүхий этгээд нь найз нөхөд, хамт ажиллагсад эсвэл ойрын харилцаатай хүнд зээл, тэтгэлэг олгох<sup>30</sup> зэрэг ашиг хүртэх хэлбэрээр нийтийн төсвийн нөөцийг хуваарилах, багш нар зүй бусаар хувиараа нэмэлт давтлага, сургалт зохион байгуулах шударга бус үйлдлүүд байсаар байна<sup>31</sup>. Судалгаанд оролцогчдоос Монгол Улсад авлига хамгийн их тархсан институцийн талаар тодруулахад боловсролын байгууллага эхний 7-д эрэмбэлэгдсэн.<sup>32</sup>
32. Сургалтын хөтөлбөрийн бодлого сул, хөтөлбөрийн шинэчлэлийг бэлтгэлгүй хийдэг бөгөөд зарим хичээлүүдийг улстөрчид болон тодорхой сонирхлын бүлгүүдийн шахалт, захиалгаар судалгааны үндэслэлгүйгээр хөтөлбөрт оруулснаар суурь боловсролын сурагчид дээд тал нь 16-19 хичээл судалж байгаа нь цар хүрээний хувьд өргөн боловч гүехэн мэдлэг олгож, өөрсдийн сонирхлын дагуу гүнзгийрүүлэн үзэх боломжийг нь боогдуулж байна. Сургалтын хөтөлбөрийн зорилго, бүрэлдэхүүн хэсэг, сурагчдад олгох ур чадварууд, агуулгын сонголт зэрэг хөтөлбөрийн чухал орцуудын талаар оролцогч талуудын саналыг тусгах ажлыг чанаржуулах шаардлагатай байна<sup>33</sup>.
33. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах ажил чанартай хийгдэхгүй байгаагийн уршгаар сургууль, багш нар өөрсдийн үзэмж, ЭЕШ шалгалтад бэлтгэх зэрэг явцуу эрх ашгийг гүйцэлдүүлж, шаардлагатай мэргэжлийн багшийн хомсдолтой байдлын улмаас зарим хичээл, агуулгыг үзэхгүй орхигдуулах, зарим агуулга, хичээлийг хэт их ачааллаар үзэж бусад хичээл, агуулгыг орхигдуулах явдал хяналтгүй үргэлжилж байна. Ийм дутагдал хувийн сургуулиуд, зарим улсын сургуулийн ахлах ангийн сургалтад дээр ажиглагдаж байна<sup>34</sup>.
34. Дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ харьцангуй бага бөгөөд хүн амын ихээхэн хэсэг нь боловсролын янз бүрийн түвшинд хамрагдан суралцаж байхад нэг сурагчид ногдох зардлын хэмжээ тун бага байна. ЕБС-ийн нэг сурагчид 1,400-1,500 төгрөгийн зардал оногддог ба их, дээд сургуулиудын хувьд төрөөс төсөв, санхүүжилтийн дэмжлэг байдаггүй.

<sup>29</sup> “Зорилтот бүлгийн иргэдийн цахим ур чадварыг үнэлэх чанарын судалгаа” Эцсийн тайлан, НҮБХХ, IRIM судалгааны хүрээлэн, 2021 он

<sup>30</sup> БШУЯ-ны вэбсайт

<sup>31</sup> “Монголын боловсролын тогтолцоон дахь шударга бус байдлын илрэлүүд ба эцэг эхээс авч буй төлбөр, хураамж” судалгааны тайлан, Б. Батжаргал, Н. Энхтуяа, Д. Тунгалаг, 2020 он

<sup>32</sup> Шударга байдлын үнэлгээ 2021”-ний судалгаа, АТГ, “Эс Ай Си Эй” ХХК, 2021 он

<sup>33</sup> Боловсролын ерөнхий хууль, дагалдан гарах хуулийн төсөлд зөвлөх үйлчилгээ үзүүлсэн судалгааны багуудын тайлангийн нэгтгэл, БШУЯ, 2021 он

<sup>34</sup> Мөн тэнд



35. Стратегийн алсын хараагүй, тэнцвэртэй эргэцүүлэлгүй, нарийн судалгаа хийж, олон нийтэд хэлэлцүүлэг өрнүүлэлгүйгээр хийсэн өөрчлөлтүүдийн үндэслэлийг боловсролын салбарын мэргэжилтнүүд, олон нийтэд хангалттай сайн тайлбарлаагүй, шийдвэр гаргах аль ч түвшинд уламжлал шинэчлэлийн залгамжийг бодолцолгүйгээр хэрэгжүүлжээ.<sup>35</sup>
36. Боловсролын салбарын хариуцлагын тогтолцоо, ил тод байдал сул, эцэг эхийн оролцоо, иргэний нийгмийн байгууллагын хяналт, оролцооны тогтвортой байнгын механизм маш хангалтгүй байна. Боловсролын хууль, тогтоомжоос харахад сургууль, цэцэрлэгт л эцэг эхийн оролцоог тодорхой хэмжээнд хуульчилсан байх бөгөөд боловсролын яам, аймаг нийслэлийн түвшин дэх иргэд, иргэний нийгмийн оролцоо хуульчлагдаагүй байна.

### **ХОЁР. Боловсролын чиглэлээр Монгол Улс олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүрэг**

37. Тэртээ 60 гаруй жилийн өмнө НҮБ-ын Ерөнхий ассамблейгаас батлагдсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 26-р зүйлд боловсролын зорилго чиглэлийг тодорхойлж өгснөөс хойш НҮБ, түүний төрөлжсөн байгууллагуудаас сурч боловсрох эрхийн асуудлыг багтаасан 20 гаруй гэрээ, зөвлөмж, тунхаглал батлагдсан.
38. Монгол Улс нь сурч боловсрох эрхийн хүрээнд Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пакт,<sup>36</sup> Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт,<sup>37</sup> Хүүхдийн эрхийн тухай Конвенц,<sup>38</sup> Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц,<sup>39</sup> ЮНЕСКО-ийн Боловсролын салбарт ялгаварлан гадуурхахын эсрэг конвенц<sup>40</sup> зэрэг заавал мөрдөх ихэнх гэрээг соёрхон баталж, нэгдэн орсон тул Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2, 3-т заасны дагуу эдгээр олон улсын хэм хэмжээ нь үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил мөрдөгдөх учиртай.
39. Монгол Улс нь олон улсын дээр дурдсан хэм хэмжээний дагуу сурч боловсрох эрхийн хүрээнд нэн даруй, аажмаар дэвшилттэйгээр хэрэгжүүлэх гэсэн хоёр түвшний үүргийг хүлээдэг. Бага боловсролыг заавал, үнэ төлбөргүй эзэмшүүлэх, аажмаар дунд, дээд боловсролыг үнэ төлбөргүй болгох, боловсролын салбарт ялгаварлан гадуурхалтыг устгах чиглэлээр аажмаар, дэвшилттэй алхмуудыг авч хэрэгжүүлэх үүргийг хүлээсэн.
40. НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооноос 1999 онд “сурч боловсрох эрх”-ийн хүрээнд гаргасан Ерөнхий зөвлөмжийн 13-т оролцогч улсын Засгийн газар нь энэхүү эрхийг хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэх үүргийг хүлээнэ хэмээн тодотгосон.
41. Төр хүлээсэн үүргээ биелүүлэхдээ боломжит бүх нөөцөө дайчлан, аажмаар, дэвшилттэйгээр хэрэгжүүлж байгаа болохоо гэрээний хяналтын байгууллагад тодорхой үе шаттайгаар илгээдэг илтгэлдээ батлан харуулах ёстой.

<sup>35</sup> Боловсролын бодлогын тойм шинжилгээ, ЮНЕСКО, БШУЯ, 2019 он

<sup>36</sup> Монгол Улс 1974 онд 11-р сарын 18-нд соёрхон баталсан.

<sup>37</sup> Монгол Улс 1974 онд 11-р сарын 18-нд соёрхон баталсан.

<sup>38</sup> Монгол Улс 1990 оны 7-р сарын 5-нд соёрхон баталсан.

<sup>39</sup> Монгол Улс 2009 оны 5-р сарын 13-нд нэгдэн орсон.

<sup>40</sup> Монгол Улс 1964 оны 11-р сарын 4-нд соёрхон баталсан.

42. Гэрээний хороодоос Монгол Улсын Засгийн Газрын илтгэлд өгсөн шүүмж, санал, зөвлөмжүүдэд сургуулийн хүртээмж, дотуур байрны нөхцөл, хангамж муу байгаад шүүмжлэлтэй хандаж, сургуулийн хэрэглэгдэхүүнийг сайжруулах, ялангуяа шинээр сургууль барих, дулаан, цахилгааны эх үүсвэр, дотуур байрны нөхцлийг сайжруулах талаар зөвлөсөн.<sup>41</sup> Төвөөс алслагдсан, хөдөө орон нутгийн хүүхдийн, ялангуяа хөвгүүдийн сургууль завсардалт, эдийн засгийн боломжоос хамаарч сургалтын чанарыг жигд бус хүртэж байгаа зэрэгт шүүмжлэлтэй хандсан бөгөөд аливаа төрлийн ялгаварлан гадуурхалтад өртөлгүйгээр сургуульд сурах тэгш боломжоор хангах, сургууль завсардалтыг бууруулах талаар ажил зохион байгуулахыг зөвлөсөн.<sup>42</sup> Мөн сургалтын чанарт шүүмжлэлтэй хандсан бөгөөд багш нарыг давтан сургах замаар сургалтын арга зүйг сайжруулах, сурах бичгийн чанарыг дээшлүүлэх асуудлуудыг тусгасан байна.<sup>43</sup> НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос Засгийн газрын 3, 4, 5-р илтгэлд өгсөн зөвлөмждөө хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилт хангалтгүй байгаад анхаарал хандуулж, ахиц дэвшил гаргах талаар зөвлөмж өгсөн.<sup>44</sup>

#### ГУРАВ. Боловсролын чиглэлээр гарч буй дэлхий нийтийн санаачлагууд

43. Тайланд улсын Жомтейн хотноо 1990 онд болсон Дэлхийн бага хурлаас “Боловсролыг бүх нийтэд: Сурч боловсрох суурь хэрэгцээг хангах нь” Дэлхийн тунхаглалыг баталснаас хойш даруй 20 гаруй жил өнгөрчээ. Энэхүү баримт бичиг батлагдсанаас 10 жилийн дараа буюу Сенегал улсын Дакар хотноо 2000 онд болсон Дэлхийн боловсролын форумтаас амлалтаа дахин бататгаж, Дакарын үйл ажиллагааны хүрээ баримт бичгийг баталж, дэлхийн бүх хүүхдэд сайн чанартай, үнэ төлбөргүй бага боловсролыг олгох хүрээнд 2015 он гэхэд хэрэгжүүлэх 6 зорилтыг дэвшүүлэн тавьсан.
44. Дэлхийн хэмжээнд боловсролын хямралыг даван туулах, боловсролыг хүний үндсэн суурь эрх гэж үзэн, төр хариуцдаг, чанартай боловсролыг охид, хөвгүүд, эмэгтэйчүүд ба эрэгтэйчүүдэд үнэ төлбөргүй эзэмшүүлэхийн төлөө засгийн газруудад нөлөөлөх зорилгоор 1999 онд “Боловсролын төлөөх дэлхий нийтийн кампанит ажил” хэмээх иргэний нийгмийн хөдөлгөөн байгуулагдсан юм. Төрийн бус байгууллагуудын томоохон сулжээнүүдийн төлөөлөгчид болох ОКСФАМ (Oxfam International), Экшин Эйд (Action Aid), Олон улсын Боловсрол байгууллага (Education International), Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг Дэлхийн марш (Global March against Child Labour) зэрэг байгууллагуудын үүсгэн байгуулсан энэ хөдөлгөөн Дакарын Чуулган эхлэхэд иргэний нийгмийн дуу хоолойг нэгтгэж чадсан ба олон улсын түвшний санхүүжилт, боловсрол эзэмших эрхийн асуудлыг чуулганы хэлэлцэх асуудалд тусгуулж, улмаар бүх нийтэд анхан шатны боловсрол эзэмшүүлэх зорилтыг Мянганы хөгжлийн зорилтуудын нэг болгож чадсан юм.
45. 2015 оны 5 дугаар сард БНСУ-ын Инчон хотноо зохион байгуулсан Дэлхийн боловсролын чуулга уулзалтад 160 орноос ирж оролцсон 1600 гаруй төлөөлөгчид

<sup>41</sup> НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороо, Зөвлөмжийн 52, 53 (g) заалт, 2005 оны 9-р сарын 21 CRC/C/15/Add.264, 14-р тал.

<sup>42</sup> Тэмдэглэл 18-ыг үзнэ үү. 51, 52, 53(a), (b), (c) заалт

<sup>43</sup> Тэмдэглэл 18-ыг үзнэ үү. 53 (f), (g)

<sup>44</sup> Зөвлөмж, НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороо, CRC/C/MNG/CO/3-4, 48, 49(c) пара, 2010 оны 1-р сарын 11-29

“Боловсрол 2030” хэмээх дэлхий дахины дараагийн 15 жилийн боловсролын зорилго зорилтуудыг баталсан билээ. Боловсрол 2030 Инчоны тунхаглал нь “Тэгш хамруулсан, тэгш боломж бүхий чанартай боловсрол бүх нийтэд олгох, насан туршдаа суралцах боломжийг бүх хүнд баталгаажуулах” зорилгыг тавьсан. Боловсрол 2030 хөтөлбөрийн гол үзэл санаа нь хэн нэгнийг ардаа орхихгүй байх явдал билээ.

46. Дээрх Боловсрол 2030 хөтөлбөр нь хожим 2015 оны 9 дүгээр сард хуралдсан НҮБ-ын Ерөнхий Ассемблейн чуулганаар батлагдсан “Дэлхийн ертөнцийг хувирган өөрчилъё” Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн 17 зорилгын 4 дэх зорилго болж батлагдсан. Дэлхийн удирдагчид ДНБ-ний өсөлтөнд шүтсэн хөгжлийн загвараас нийгэм, эдийн засаг, байгаль орчны хөгжлийг улс орны хөгжлийн тулгын гурван чулуу гэж үзэх тогтвортой хөгжлийн загвар руу шилжихээ тунхаглан зарласан билээ. Дэлхий ертөнцийг хувирган өөрчлөх хүчин чадал боловсролд байгаа гэдэгтэй санал нэгдэж 4.7 дугаар зорилтыг томъёолсон юм.
47. Боловсролыг хувьсган өөрчлөх дэлхий нийтийн санаачлагыг НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга гаргаж, Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол улсын амлалтыг 2022 онд НҮБ-ын “Хувьсаж буй боловсрол” Дээд хэмжээний чуулга уулзалтад танилцуулсан. Монгол Улсын хүүхэд, залуучууд, багш, судлаачид, иргэний нийгмийн байгууллага, аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчид, хэвлэл мэдээллийн болон төрийн байгууллагын төлөөлөл зэрэг олон талын оролцоог хангасан үндэсний хэмжээний хэлэлцүүлгийг үе шаттайгаар зохион байгуулж, ирээдүйн боловсролын дүр төрх, алсын хараа, амлалтыг тунхагласан<sup>45</sup>.
48. “Ирээдүйн боловсролыг дахин төсөөлөх нь: Нийгмийн шинэ гэрээ” хэмээх ЮНЕСКО-гийн тайлан 2021 онд гарч, ирээдүйг хувьсган өөрчлөхийн тулд шударга бус байдлыг засч залруулах ёстой бөгөөд боловсролд нийгмийн шинэ гэрээг байгуулахыг санал болгосон. Хүн бүрийн чанартай боловсрол насан туршдаа эзэмших эрхийг хангах, боловсролыг нийт олны хүчин чармайлт, хамтын сайн гэж үзэн бэхжүүлэх<sup>46</sup> 2 тулгуурт үндэслэхийг санал болгосон.
49. Монгол Улсын тухайд “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл 2010 онд байгуулагдаж, боловсролын талаарх суурь үзэл санаагаа илэрхийлсэн Тунхагт нэгдэж, дүрмээ баталсан юм. Энэ байр суурийн Тунхагийг хэрэгжүүлэхэд баримтлах үйл ажиллагааны хүрээгээ тодорхойлох, Тогтвортой хөгжлийн зорилго батлагдсантай холбоотойгоор боловсролын талаар баримтлах байр сууриа нэгтгэх, дэлгэрүүлэх үүднээс боловсруулсан болно. Боловсролыг хувьсган өөрчлөх дэлхий нийтийн санаачлага өрнөж байгаа хүрээнд өөрсдийн байр сууриа дахин тодорхойлж, энэхүү баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулан баталж байна.

<sup>45</sup> “Хувьсаж буй боловсрол” Монгол улсын санаачилга: Ирээдүйн төлөө хамтдаа, 2022 он

<sup>46</sup> Ирээдүйгээ хамтдаа дахин төсөөлөх нь: Нийгмийн шинэ гэрээ, ЮНЕСКО, 2021 он



56. Сурч боловсрох эрхийн хүрээнд улс орны засгийн газруудын хүлээж буй үүргийг 4А<sup>48</sup> буюу хүрэлцээтэй, хүртээмжтэй, хүлээн зөвшөөрөгдсөн, цаг үетэйгээ зохицсон байх гэсэн зарчмуудын хүрээнд авч үзэх боломжтой юм.<sup>49</sup>
57. НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооноос 1999 онд “сурч боловсрох эрх”-ийн хүрээнд гаргасан 13-р Ерөнхий зөвлөмжид “Оролцогч улсын Засгийн газар нь 4А зарчмын дагуу сурч боловсрох эрхийг хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэх үүргийг хүлээнэ” хэмээн тодотгосон. Нөгөө талаас аливаа эрхийг мөн чанараар нь нэг мөр ойлгох нь тухайн эрхийн хүрээнд хийх үйл ажиллагаагаа тодорхойлох, хэрэгжилтэнд нь үнэлгээ өгөхөд тун чухал. Тиймээс энэхүү 4А зарчим бол сурч боловсрох эрхийн агуулгыг ойлгож, хэрэгжүүлэхэд тун чухал эх сурвалж юм.
58. Боловсрол бүхэлдээ хүрэлцээтэй эсэх, боловсрол эзэмшихэд учирч буй аливаа саад тотгорууд байгаа эсэх, боловсролын агуулга хэрхэн тодорхойлогдсон, боловсрол нь нийгмийн ялгаатай бүлэг, хувь хүний хэрэгцээг хангахуйц байж чадаж буй эсэх зэрэгт 4А зарчим анхаарал хандуулдаг. Гэвч 4А зарчим нь боловсролын тогтолцооны үе шат бүрт ялгамжтайгаар тодорхойлогдоно.
59. Эмзэг, гадуурхагдсан, хүнд нөхцөлд амьдарч байгаа хүмүүсийн сурч боловсрох эрхээ эдлэх боломж нөхцөл хэр байгаа нь боловсролыг үнэлэх нэн чухал үзүүлэлт болох учиртай.
60. Боловсрол хүрэлцээтэй байх хүрээнд бүх шатны боловсролын байгууллагад элсэн суралцах боломж хэр байгааг авч үздэг. Олон улсын гол баримт бичгүүдэд наад зах нь бага боловсрол үнэ төлбөргүй, албан ёсны байх талаар заасан.<sup>50</sup> Энэ нь аль ч улс оронд бага боловсролыг эрэгтэй, эмэгтэй, баян, ядуу эсэхээс үл хамааран хүн бүр эзэмших эрхтэй гэсэн үг.

Манай улсын тухайд ерөнхий боловсролыг Монгол Улсын иргэн бүр үнэ төлбөргүй эзэмших эрхтэй бөгөөд суурь боловсролыг заавал эзэмших үүргийг хүлээдэг нь ололттой.<sup>51</sup> Харин сургуулийн өмнөх боловсролыг үнэ төлбөргүй эзэмших боломжтой ч хүчин чадлаасаа хамаараад бүгдэд хүрэлцээтэй биш байна. Мэргэжлийн боловсролын тухайд үнэ төлбөргүйн зэрэгцээ, тэтгэмж олгож байгаа нь мөн л дэвшилттэй. Дээд боловсрол төлбөртэй бөгөөд элсэн суралцах боломж суралцагчдын чадамжаас хамаарахаар зохицуулсан.

Дээрх зохицуулалт нь олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ дэвшилттэйгээр хэрэгжүүлж байгаа хэрэг юм. Энэ хүрээнд дараагийн яригдах асуудал бол сургуулийн анги, танхим, ширээ сандал, ариун цэврийн өрөө, ундны цэвэр ус, тухайн улсын хувьд боломжтой цалин хөлстэй, мэргэжлийн багшлах боловсон хүчин, номын сан, мэдээллийн технологи гэх мэт нь сурах насны хүүхдэд хүрэлцээтэй тоо хэмжээгээр байх асуудал юм.<sup>52</sup>

<sup>48</sup> 4А-ийн зарчим: “Availability, accessibility, acceptability, adaptability”

<sup>49</sup> Manual on Rights-Based Education, Katarina Tomasevski, pp i. (НҮБ-ын Боловсролын тусгай илтгэгч асан Катарина Томасевскийн Эрхэд суурилсан боловсролын талаарх гарын авлага).

<sup>50</sup> 26-р зүйл, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1948, 13-р зүйл, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт, 1966, 29-р зүйл Хүүхдийн эрхийн тухай конвенц, 1989 он

<sup>51</sup> 2-р бүлгийн 16-р зүйл 7-р заалт, Монгол Улсын Үндсэн хууль, 1992.01.13, 6-р зүйлийн 2,3-р заалт, Боловсролын тухай хууль, 2002.05.03

<sup>52</sup> 6(а) заалт, 13-р Ерөнхий Зөвлөмж, НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо, E/C.12/1999/10, 1999 он

Бид боловсролын хүрэлцээг албан боловсролын тогтолцооноос гадна албан бус боловсролын тогтолцооны хүрээнд харах учиртай. Энэ хүрээнд мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх явдал ч мөн чухлаар тавигдах ёстой. Одоогийн байдлаар төрийн шууд оролцоотой зохион байгуулагдаж буй эдгээр сургалт уламжлалт арга барилаасаа төдийлөн салаагүй хэвээр байна. Үүний улмаас тодорхой цаг хугацаа, хөрөнгө зарцуулж, ажилгүй, мэргэжилгүй хүмүүсийг нарийн боовчин, үсчин, тогооч зэрэг мэргэжлээр сургаж байгаа ч төгсөгчид ажилгүй байсаар байна. Гэтэл өндөр зэрэглэлийн кранист зэрэг барилгын бусад мэргэжлийн хүмүүс дутагдалтай байсаар байна. Үүний зэрэгцээ өдөр тутам хувьсан өөрчлөгдөж байгаа технологийн дэвшил ажиллагсдыг хурдан хоцрогдоход хүргэж байгаа тул ажлын байрны тасралтгүй сургалтын бодлогыг төрөөс дэмжих зайлшгүй шаардлагатай болж байгаа юм. Энэ бодлого байхгүйн улмаас ахмад ажилтнууд ажлын байрнаас шахагдахад хүрч, шинээр ажилд орохыг хүсэвч насаараа ялгаварлагдах нь түгээмэл байна.

61. НҮБ-ын Эдийн засаг нийгэм соёлын эрхийн Хорооны 13-р Зөвлөмжид “Хүртээмжтэй байх асуудлыг үл ялгаварлан гадуурхах, биет хүртээмж, эдийн засгийн хүртээмжтэй байдал” хэмээх 3 хэмжигдэхүүнээр авч үзсэн. Төрөөс боловсролыг хүртээмжтэй байлгах үүрэг нь боловсролын салбарт аливаа хэлбэрийн ялгаварлан гадуурхалтыг бүрэн хориглосон эсэх, хүн бүр сурч боловсрох тэгш боломжоор хангагдсан эсэхээр хэмжигддэг.<sup>53</sup> Өөрөөр хэлбэл, хүн бүрт боловсрол эзэмших тэгш боломж байгаа эсэх тухай асуудал юм. Боловсролын бодлогыг өргөн хүрээтэй болгон нийгэмд ялгаварлах байдал үүсгэх шалтгаан болгохгүйг хичээх ёстой.<sup>54</sup> Эдийн засгийн нөөц боломж, улс орны хөгжлөөс шалтгаалан хүн бүрийг дээд боловсролтой болгох боломж хязгаарлагдмал байдаг ч энэхүү хязгаарлалт нь шударга, ил тод, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэсэн, жендэрийн тэгш байдлыг хөхүүлсэн зарчимд л тулгуурласан байх ёстой.

Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, үндэстний цөөнх, малчдын хүүхэд, шилжин суурьшигчдын хүүхэд, нийгэм-эдийн засгийн статус доогуур өрхийн хүүхдүүд, жирэмсэн охид, хүүхэд төрүүлсэн өсвөр насны охид, ЛГБТ хүүхдүүд, төвөөс алслагдсан нутагт амьдарч байгаа хүүхдүүдийн боловсрол эзэмших боломж хангагдаж чадсан эсэхээр энэхүү зарчмын хэрэгжилтийг хэмжих боломжтой. Өнөөдөр суралцахуй, сургалтын хөтөлбөр, арга зүй, үнэлгээний тогтолцоо болон сургууль, түүний гадаад, дотоод орчны дэд бүтэц нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрхээ эдлэх тэгш боломжийг хязгаарласаар байна. Ялгаварлан гадуурхалтыг хуулиар хориглосон хэдий ч энэ заалт практикт хэрэгжихгүй байгаа нь тухайн хүмүүсийг шууд бус хэлбэрээр ялгаварлан гадуурхаж байгаагийн нэг тод жишээ юм. Олон улсын хувьд ялгаварлан гадуурхалтыг хориглосон зүйлүүдийн хэрэгжилтийг хэмжиж болохуйц статистик мэдээ гардаг эсэхийг авч үзээд, гардаггүй бол энэ чиглэлээр статистик мэдээ гаргах талаар ажил зохион байгуулах шаардлагатай гэж улс орнуудад зөвлөж байна.<sup>55</sup>

Үндэстний цөөнхийн хүүхэд өөрийн эх хэлээр сурах нь 2 дахь хэлээр сурахаас илүү

<sup>53</sup> Тэмдэглэл 26-г үзнэ үү. 6(b) заалт

<sup>54</sup> Боловсрол: эрдэнэсийн эргэн тойронд, Jacques Delors, UNESCO, УБ, 2005 он

<sup>55</sup> Тэмдэглэл 23-ыг үзнэ үү. 30-р тал

үр дүнтэй байгааг улам олон судалгаа нотолсоор байна. Мөн эх хэлээр нь хичээл заахад удахгүй албан ёсны хэлээ сайн сурч, улмаар бусад хичээл буюу академик мэдлэг эзэмшихэд бэлэн болдог байна. Тэд сургуульдаа сурсаар байх магадлал нэмэгддэг<sup>56</sup>. Боловсролын бодлогод хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнхийн хүүхдүүд эх хэлээрээ суралцах эрхийг баталгаажуулан, хос хэлний хөтөлбөрөөр суралцах оновчтой загварыг сүүлийн үеийн танин мэдэхүйн судалгаа, нотолгоонд суурилан сонгон хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Биет хүртээмжийн тухайд боловсролын байгууллагыг газарзүйн тохиромжтой байршилд хүүхэд аюулгүй хүрэхээр байлгах (оршин суугаа газрын зэргэлдээ сургууль барих) замаар эсвэл орчин үеийн шинэ технологийн тусламжтайгаар (алсын зайн сургалт) суралцагчдад хүргэх боломжийг олгох тухай асуудал юм. Улаанбаатар хотын алслагдсан дүүрэгт амьдарч байгаа хүүхдүүдийн тухайд сургуульдаа хүрэх, буцах замдаа халдлагад өртөх, эрүүл мэнд, сэтгэл санааны хохирол амсах явдал гарч байгаа нь энэ зарчмын хэрэгжилтэнд анхаарал хандуулах шаардлагатай болохыг харуулж байгаа юм.

Эдийн засгийн хүртээмжтэй байдал гэдэгт боловсролын төлбөрийг хүн бүр төлөх боломжтой байх тухай асуудал багтаж байгаа бөгөөд энэ нь тухайн улсын боловсролын тогтолцоонд мөрдөгдөж байгаа үнэ төлбөртэй боловсролын байгууллагад суралцагчдад хамаарах ойлголт юм. Энэ хүрээнд ядуу өрхийн суралцагчид дээд боловсрол эзэмшихэд зориулан төрөөс үзүүлэх дэмжлэг, түүний хүртээмжийн асуудал мөн хамаарна.

62. Боловсролын агуулга, хөтөлбөр, сургалтын арга зүй нь суралцагчдад чанартай боловсрол эзэмших боломжийг олгосон, боловсролын зорилгод нийцсэн байх, төрөөс боловсролын наад захын стандартыг тогтоох зэрэг нь боловсрол хүлээн зөвшөөрөгдсөн байх хүрээнд яригддаг гол асуудлууд юм.<sup>57</sup> Нэг талаас сурч боловсрох эрхийн хэрэгжилт нь чанартай боловсрол эзэмшиж чадаж буйгаас хамаарах бөгөөд нөгөө талаас чанартай боловсрол нь бие хүн болгон төлөвших, авъяас, ур чадвараа хөгжүүлэх гол түлхүүр билээ.

“Чанартай боловсрол”-ын талаарх ухагдахуун нь олон улсын гэрээ конвенцид төдийлөн нарийвчлан тусгагдаагүй тул энэ асуудлыг өөрийн орны хууль тогтоомжид нарийвчлан тусгах шаардлагатай юм.<sup>58</sup> Жомтейн, Дакарын баримт бичгүүдэд туссанаар боловсролын чанарын тухай асуудлыг суралцагч (эрүүл, урам зориг дүүрэн), үйл явц (сургалтын идэвхтэй арга зүй ашигладаг мэдлэгтэй багш нар), агуулга (хамаарал бүхий хөтөлбөр) болон тогтолцооны (сайн засаглал, нөөцийн эрх тэгш хуваарилалт) хүрээнд гаргаж ирсэн. Хүний эрх, эрхэм чанарыг нь хүндэтгэн үздэг, суралцах тэгш боломжтой байгааг нь бүрэн дүүрэн мэдрүүлдэг, ялгаатай байдлыг нь хүлээн зөвшөөрч, ялгаварладаггүй сургалтын орчинд л эрүүл, урам зориг дүүрэн суралцагчид байх нь тодорхой.

Боловсролын үйл явцад хүүхэд төвтэй сургалтын идэвхтэй арга зүйг нэвтрүүлэх талаар олон чухал санал, санаачлага гарч, баримт бичиг боловсруулсан хэдий ч

<sup>56</sup> LOUD AND CLEAR: Effective Language of Instruction Policies for Learning, World Bank, 2021

<sup>57</sup> Тэмдэглэл 26-г үзнэ үү. 6 (с) заалт

<sup>58</sup> Тэмдэглэл 23-ыг үзнэ үү. 28-р тал

практикт хэрэгжилт туйлын хангалтгүй байгаа юм. Энэ нь багш бэлтгэх тогтолцоогоо эргэн харах шаардлагатай байгаагийн илрэл болж байна. Уламжлалт сургалтын арга зүйгээр суралцаж байгаа оюутнууд төгсч гараад, хэдэн гарын авлага, чадвар дээшлүүлэх зарим сургалт (нөөц хомс гэсэн шалтгаанаар нь 100, 100-аар нь суулгаж заадаг богино хугацааны сургалт)-д хамрагдаад л идэвхтэй арга зүйг сургалтандаа ашиглах чадвартай болохгүй нь тодорхой.

Сургалтын чанарын тухай асуудлыг хөндөж байгаа бол агуулгыг орхигдуулах боломжгүй. Агуулга нь суралцагчид амьдралд бүрэн дүүрэн итгэлтэй байх, ур чадвараа хөгжүүлэх боломжийг олгосон байх ёстой. Нөгөө талаас агуулга нь хүний эрх, жендэрийн тэгш эрхэд суурилсан байж л чанартай байх шалгуурыг хангах болно.

Бие даан амьдрах чадвартай, өөртөө итгэлтэй, өөрийгөө үр дүнтэй, зохистой байдлаар илэрхийлэхийн зэрэгцээ бусдыг сонсож, ялгаатай үзэл бодолд хүндэтгэлтэй ханддаг, хүлээцтэй бие хүн болон төлөвшихөд хүний эрхийн боловсрол туйлын чухал билээ.

Хамаарал бүхий агуулга гэдэг нь суралцагчид, тэдний гэр бүл, нийгмийн эрэлт хэрэгцээ, зорилтыг хангахуйц байхыг хэлнэ. Мөн төрийн бодлоготой уялдах бөгөөд өсөн нэмэгдэж байгаа эдийн засгийн эрэлтэд нийцэхүйц ур чадвар бүхий боловсон хүчнийг бэлтгэх зорилтод нийцэх учиртай. Түүнчлэн боловсролын агуулгад олон улсын гэрээ хэлэлцээрт туссан хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх үзлийг төлөвшүүлэхэд анхаарсан байх шаардлагатай. Боловсролын чанарыг хэмжих хэмжүүрүүд мөн хүний эрхийн ба боловсролын салбарт үл ялгаварлан гадуурхах зарчмуудад суурилсан байх учиртай.

Боловсролын чанарыг хангахын тулд багш нарын цалин хөлс, нийгмийн баталгаа зохих хэмжээнд байх, тэдний хөдөлмөрлөх, чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрх бүрэн баталгаажсан байх шаардлагатай. Ямар ч улсын боловсролын чанар багшийнхаа чанараас давж гардаггүй. Мэргэжлийн стандартаа баримтлах, хамгаалахад багшид үзүүлэх дэмжлэгийн тогтолцоог төрийн зүгээс бий болгох шаардлагатай.

Түүнчлэн сургалтын арга зүй болон сургуулийн дотоод дүрэм, журам, байгууллагын соёл маш чухал нөлөөтэй. Сургуулийн орчин нь өөрөө хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэсэн, хамгаалсан, оролцогч талуудын (багш, эцэг эх, сурагчид гэх мэт) ардчилсан оролцоотой байх учиртай. Гэтэл амьдрал дээр өөр дүр зураг харагдаж байна. Сурах бичиг, сургалтын бусад хэрэглэгдэхүүн, арга зүй болон боловсролын байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхийн үүднээс хийх дүн шинжилгээ үгүйлэгдэж байна.

63. Боловсрол цаг үетэйгээ нийцсэн, өөрөөр хэлбэл нийгмийн өөрчлөлт хөдөлгөөнд таарч зохицсон,<sup>59</sup> түүнчлэн ялгаатай хэрэгцээтэй бүлгийн хувьд боловсролыг олж авах арга замыг өөр өөр байдлаар томъёолсон, уян хатан байж, хүний бүх эрхийг хөхүүлэн дэмжихэд чиглэх ёстой.

Сургууль, дотуур байран дахь үе тэнгийн хүчирхийлэл, дарамтаас урьдчилан сэргийлэх, өсвөр насныхны сэтгэцийн эрүүл мэндийн асуудалд анхаарах, сургууль дээрх нийгмийн ажлын үйлчилгээг чанаржуулах, боловсролын ялгаатай хэрэгцээг

<sup>59</sup> Тэмдэглэл 26-г үзнэ үү. 6 (d) заалт



хангах зэрэг асуудлуудад боловсролын салбар анхаарах шаардлагатай байна.

Цаг үетэйгээ нийцсэн байхын тулд боловсрол тухайн нийгмийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн байх ёстой. Тэгвэл өнөөгийн мэдээллийн технологийн өндөр хөгжил нь ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийг компьютер, интернэтийн тодорхой мэдлэг чадварыг эзэмшсэн байхыг шаардаж байна. Гэтэл төвөөс алслагдах тусам энэхүү хэрэгцээ нь улам бүр мөрөөдлийн шинжтэй зүйл болон хувирч байгаа билээ. Энэ байдалд шүүмжлэлтэйгээр хандаж, боловсролыг хэрхэн цаг үетэйгээ нийцсэн, суралцагчдын өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангаж чадахуйц болгох вэ гэдэг дээр анхаарах цаг болоод байна.

Боловсролын салбарт сүүлийн үед хувийн хэвшлийн оролцоо нэмэгдэж байгаатай уялдуулан хүүхдийн сурч боловсрох эрх, эцэг эхийн хүүхдийнхээ боловсролын талаар сонголт хийх эрх чөлөөг эдлүүлэхийн тулд төрөөс хувийн хэвшлийн сургууль, цэцэрлэгийн талаарх зохицуулалт, хяналтаа сайжруулах шаардлага гарч байна.

64. Бидний бий болгохыг зорьж байгаа боловсролын тогтолцоонд зайлшгүй яригдах асуудал бол сайн засаглал, боловсролын салбарын төсөв, нөөцийн эрх тэгш, мэдрэг хуваарилалт зэрэг юм. Хууль тогтоомжоор ил тод байдал, оролцооны асуудлыг хуульчлан зохицуулсан хэдий ч шийдвэр гаргах үйл явц хаалттай, оролцоонд тулгуурладаггүй, эсвэл ёс төдий оролцоотой байх явдал түгээмэл байна. Сургуулийн захиргаа сурагчид, эцэг, эх, багш, олон нийтийн өмнө хариуцан тайлагнадаггүй, үйл ажиллагаа, төсөв нь иргэдийн хяналтаас гадуур байсаар байна.

Сургуулийн өөрөө удирдах байгууллагын сонгууль хэрхэн явагддаг талаар сурагчид тодорхой ойлголтгүй. Нөгөө талаас энэ байгууллагад сонгогдон ажиллаж байгаа сурагчид ямар чиг үүрэгтэй байх ёстойгоо мэдэхгүй байгаа нь энэ байгууллагыг нэр төдий болгон хувиргаж байна. Цаашлаад ангийн дарга, онц сурлагатан, ахлах ангийн сурагчид л энэ зөвлөлийн гишүүн байна гэсэн өрөөсгөл ойлголт байгааг ч залруулах шаардлагатай юм.

Сайн засаглалын тухай асуудал нь боловсролын байгууллага тус бүрээр яригдахаас гадна боловсролын тогтолцооны түвшинд ч ярих асуудал мөн билээ. Өнөөдөр боловсролын салбарт гарч байгаа бодлого, шийдвэр хэр оролцоонд тулгуурлаж байна, хэрэгжилтэнд хөндлөнгийн мониторинг хийх боломж хэр байгаа зэргээр ардчилсан засаглал энэ салбарт тогтож чадсан эсэхийг хэмжих боломжтой.

Гэвч өнөөгийн эрх зүйн зохицуулалт, практикийг шинжилж үзэхэд иргэдийн оролцоо шийдвэр гаргах түвшинд туйлын хангалтгүй байна. Иргэд аливаа шийдвэр гаргах үйл явцад шийдвэр гаргагчдын хүссэн үед биш, өөрсдийн хүсэл зоригоор, сайн дурын үндсэн дээр оролцож, өгсөн санал нь туссан эсэх, тусаагүй бол яагаад гэдэг шалтгаанаа мэдэх боломжтой утга учиртай оролцоог эрх зүйн хүрээнд институтчилах шаардлагатай байна. Оролцоог хангахдаа нийгмийн бүх бүлэг, тэр дундаа эрх мэдлийн цөөнхийн оролцоог хангах явдлыг чухалчлан үзэх ёстой.

Нөгөө талаас боловсролын стандартыг хэрэгжүүлэх үүргээ төр хангалттай биелүүлэхгүй байгааг анхаарах шаардлагатай юм. Жишээ нь, биеийн тамирын заалгүй хувийн сургууль ерөнхий боловсролын сургалт эрхлэх зөвшөөрөл авч

чадсан тохиолдлууд байна. Цаашлаад сургуулиуд сургах ёстой зарим агуулгыг огт оруулахгүй байх нь ч түгээмэл. Тэр дундаа суралцагчдын бие хүн болон төлөвшихөд зайлшгүй шаардлагатай хөтөлбөрүүд огт орохгүй, орсон ч хэлбэр төдий байгаа нь судалгаа, шинжилгээний явцад илэрсээр байна. Энэ тохиолдолд боловсролын хяналтын байгууллага, иргэдийн хяналт, оролцоо туйлын чухал билээ.

65. Боловсролын салбарын төсөв, нөөцийн хуваарилалт нь сургалтын чанарт нөлөөлөх өөр нэг чухал хүчин зүйл билээ. Энэ хүрээнд эцэг эхээс төсөвт тусдаггүй зардлуудыг шаардах гэх мэтээр эдийн засгийн боломж муутай эцэг эхэд сургуулийн зүгээс дарамт учруулж, улмаар хүүхдийг ялгаварлан гадуурхах, дарамтлах, сургууль завсардахад хүргэж байгаа нэг шалтгаан болж байгааг анхаарах шаардлагатай.

Боловсролын салбарт ДНБ-ий наад зах нь 4-6 хувийг, улсын төсвийн доод тал нь 15-20 хувийг зарцуулах олон улсын нийтлэг жишигт хүрэхийн тулд боловсролд зарцуулах төсвийг нэмэгдүүлж, хуваарилалтын эрх тэгш байдал, зарцуулалтын хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Нийгмийн ялгаатай бүлгүүдэд хөрөнгө нөөцийг жендэрийн болон бусад ялгаатай хэрэгцээгээр эрх тэгш байдлыг хангах үүднээс мэдрэг хуваарилахтай холбоотой асуудалд бид бүхэн анхаарал хандуулах шаардлагатай юм.

#### **ТАВ. Бид юу хийх ёстой вэ?**

- Эвдрэн сүйдэж буй дэлхий ертөнц, хямрал, зөрчил мөргөлдөөн дундах үл хүлцэл, нийгэм эдийн засгийн тэгш бус байдалд “эзлэгдсэн” байгаа нь боловсролын талаарх бидний харах харааг тэлж, боловсролд нухацтайгаар анхаарч, шийдвэртэйгээр хариу үйлдэл үзүүлэх ёстойг ухаарууллаа. Тиймээс итгэл үнэмшилтэйгээр, бүхий л төсөөллөө дайчлан эв нэгдэлтэйгээр боловсролыг хувьсган өөрчлөх амлалтыг авч байна.
- Боловсролын салбарыг 4А зарчим болон хүний эрх, жендэрийн эрхийн зарчимд суурилан үнэлэх боломжтой тоон болон чанарын мэдээллийг тодорхойлох чиглэлээр төр, олон улсын байгууллагатай хамтран ажиллах, ялангуяа хүнд нөхцөлд байгаа, гадуурхагдсан бүлгийн хүмүүсийн боловсрол эзэмших эрх тэгш боломжийг хангах бодлого боловсруулж, төсвийг хуваарилах, ахиц дэвшлийг үнэлж, олон нийтийн өмнө хариуцлага хүлээхэд нөлөөлөх.
- Төрөөс сурч боловсрох эрхийн хүрээнд олон улсын гэрээ хэлэлцээрээр хүлээсэн үүргээ аажмаар буюу дэвшилттэйгээр хэрэгжүүлж байгаа эсэхэд үр дүнтэй мониторинг хийж, нөлөөллийн ажил зохион байгуулах.
- Сайн сургуультай болох үйл явцыг орон нутагт өрнүүлж, эцэг эх, багш, орон нутгийн удирдлагуудыг эрхмэдэлжүүлэх, улмаар үндэсний хэмжээнд нэвтрүүлэхэд төрийн ба хандивлагч байгууллагуудтай хамтран ажиллах.
- Иргэний нийгмийн бие даасан байр сууринаас үнэлгээ, судалгаа, дүн шинжилгээ хийж, баримт нотолгоонд суурилсан бодлогын санал боловсруулж, төр болон бусад оролцогч талуудын анхааралд хүргэн өргөнөөр хэлэлцүүлэх, асуудлыг шийдвэрлэх оновчтой гарц, шийдлийг дэвшүүлэх.

- Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөрийг шинэчлэх үйл явцад идэвхтэй оролцогч байж, хүүхэд нэг бүрийг өөрийн чадавх потенциалдаа тултал хөгжих чанартай боловсрол эзэмших, өөрийн орон нутаг, улс орон төдийгүй дэлхий ертөнцийн хөгжлийн үйл явцад бүтээлч, идэвхтэй оролцогч байх, ардчилсан нийгмийн иргэн болж төлөвшихөд туслах сургалтын агуулга, хөтөлбөрийг боловсруулахад хувь нэмрээ оруулах
- Боловсролын салбарт олон талт зөвлөлдөх механизм байгуулан салбарын төлөвлөлт, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хянаж үнэлэх үйл явцад иргэний нийгмийн бодит оролцоог хуульчлах, Тогтвортой хөгжлийн 4 дүгээр зорилгыг хэрэгжүүлэхэд идэвхтэй үүрэг гүйцэтгэх
- Багшлах мэргэжлийн нэр хүндийг өргөх, ёс зүйг дээшлүүлэх, мэргэжлийн хараат бус байдлыг хангах үүднээс багшлах мэргэжлийн байгууллагыг байгуулах, мэргэжлийн стандартыг тогтоох зэрэг санал санаачилгыг өрнүүлж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах
- Боловсролын санхүүжилтийг ядуурал, хүчирхийлэл, ажилгүйдэл, өвчлөл, жендэрийн тэгш бус байдлыг бууруулах хөрөнгө оруулалт гэж үзнэ. Хүүхдийн сайн сайхан байдал, бүх талын хөгжилд төвлөсөн хууль, бодлого, сургууль, хичээл, үйл ажиллагааны төлөө зорих ба хүүхдэд чиглэсэн салбар дамнасан цогц үйлчилгээг үзүүлэх, чанартай боловсрол олгох хангалттай санхүүжилтийг дайчлахын төлөө нөлөөлж ажиллах
- Боловсролын тогтолцоог илүү эрх тэгш, хүртээмжтэй, хариу үйлдэл үзүүлэх чадвартай, уян хатан болгохын тулд тогтолцооны талаар эргэцүүлэн тунгаах, шинэлэг санаачилга гаргах, өөрчлөхөд хувь нэмрээ оруулах, хамтран ажиллах
- Боловсролын салбарт сүүлийн жилүүдэд эрчимтэй нэвтэрч байгаа зах зээлийн механизмд чиглэсэн бодлого, төр-хувийн хэвшлийн түншлэлийг дэмжсэн санхүүжилтийн бодлого зэрэг богино хугацааны үр дүнд чиглэсэн шийдлүүдийн боловсролын хүртээмж, төрийн боловсролын тогтолцоо, эрх тэгш байдалд урт хугацаанд үзүүлэх нөлөөнд дүн шинжилгээ хийх, байр сууриа илэрхийлэх
- Хамтын ажиллагаагаа өргөжүүлж, Монгол улсын боловсролын тогтолцоог орчин үеийн хэрэгцээ, хүмүүнлэг ардчилсан нийгмийн зарчимд нийцсэн, үр дүнтэй, хариуцлагатай болгох үндэсний хөдөлгөөнийг өрнүүлж, хүчээ нэгтгэн, улс орныхоо өнцөг булан бүрд, баг, хорооноос дүүрэг, хот, аймаг, үндэсний түвшинд хүртэл олон талт үйл ажиллагаа явуулах.

*“Боловсрол: Мөнгө, чанар, хариуцлага” Иргэний нийгмийн үндэсний хоёрдугаар чуулганы оролцогчид хэлэлцэн, батлав. 2011 оны 8-р сарын 27-ний өдөр*

*“Боловсрол: Чанар, санхүүжилт, хариуцлага” Иргэний нийгмийн үндэсний наймдугаар чуулганы оролцогчид нэмэлт өөрчлөлт оруулан батлав.*

*2017 оны 11-р сарын 2-ны өдөр*

*“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн*

*Бүх гишүүдийн Тавдугаар чуулганаар нэмэлт өөрчлөлт оруулан батлав.*

*2023 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр*

## **“БҮХ НИЙТ БОЛОВСРОЛЫН ТӨЛӨӨ!”**

### **Иргэний нийгмийн үндэсний эвслийн ТУНХАГ**

Боловсрол нь хүн бүрийн өдөр тутмын амьдралд, насан турш нөлөөлөх үндсэн эрх, хүний хөгжлийн түлхүүр бөгөөд иргэн бүрт чанартай боловсрол олгох нь төрийн хүлээх гол үүрэг хариуцлага гэдэгт итгэн;

Өнөөгийн тогтолцоонд боловсролыг явцуу тодорхойлдог, хүн бүрийн ялгаатай байдлыг харгалздаггүй, ялгаварлан гадуурхдаг, хангалттай санхүүжилт олгодоггүй зэргээс шалтгаалан бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх үйл явцад цогц хандлага дутагдаж; боловсролын тогтолцооны үр өгөөж нь хувь хүний хүсэл тэмүүлэл, нийгмийн эрэлт хэрэгцээнээс асар зөрүүтэй байсаар ирсний улмаас үнэ цэнэтэй амьдарч, амьдралын чанараа дээшлүүлэх боломж олгохгүй байгаад сэтгэл зовнин;

Энэ нь эрх мэдлийн шударга бус бүтцийг бий болгож, тэгш бус байдлыг хадгалж үлдэх арга зам болж байгааг эсэргүүцэн;

Боловсролын чанар, хүртээмж, хариуцлагатай байдлын төлөө хүчээ нэгтгэн ажиллаж, энэ үйл явцад хувь хүн, иргэний нийгмийн байгууллага, бүлгүүдийг өргөнөөр татан оролцуулж, өргөн суурьтай, зохион байгуулалттай, хүчтэй хөдөлгөөн бий болгохыг чухалчлан;

Энэ үйл явцад нийгмийн бүх бүлэг, ялангуяа эрх мэдлийн цөөнхийн оролцоог хангахыг онцлон;

Иргэд, бүлгүүдийн мэдлэг, чадварыг хөгжүүлж, тулгарсан асуудлаа гаргаж ирэх, шийдлийг шаардах, хариуцлага тооцох чадавхтай болоход нь дэмжлэг үзүүлэхийг эрмэлзэн;

Боловсролын тогтолцоог хүний мэдэх, бүтээх, хүний ёсоор хамтран амьдарч, нэр төртэйгээр оршиход суралцахуйц, хувь хүний потенциал, чадвар, чадавхыг нээж, эерэг зан үйл, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн, хүмүүнлэг, ардчилсан, хүн бүрийн эрхийг хангасан, тэгш хүртээмжтэй болгон өөрчлөхийг эрхэмлэн;

Хүүхэд, эцэг эх, багш, орон нутгийн бүлгүүд болон үндэсний, хэлний, соёлын, бэлгийн цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, орлого багатай иргэд зэрэг дуу хоолойгоо хүргэж, шийдвэр гаргахад оролцож чадахгүй байгаа бүлгүүдийг эрх мэдэлжүүлэх зорилгоор боловсролын тогтолцоо, бодлогод хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чадавхыг бүрдүүлэх, нөлөөлөх ур чадвараа дээшлүүлэх шаардлагыг ухамсарлан;

Хүний эрх, жендэрийн тэгш эрх, үл ялгаварлан гадуурхах, хүчирхийллээс ангид, хүлээцтэй байх, нээлттэй, ил тод, хариуцлагатай байх зарчмыг баримтлан;

Монгол улсад боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах, төсвийг хянах, хариуцлага шаардах, бодлогод нөлөөлөх үндэсний кампанит ажил зохион байгуулах зорилгоор эвсэн нэгдсэнээ тунхаглаж байна.